



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 167

Мандалговь

Хөрөнгө бэлтгэж бүртгэх,  
акталж устгах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, "Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль", Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 3 дугаар зүйлийн 3.1 "б", 3.2.6 "д", дэх заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Уламжлалт анагаах ухааны төвд хавсралтын дагуу өөрийн хөрөнгөнөөс 1'690'000 /нэг сая зургаан зуун ерэн мянга/ төгрөгийн эд хөрөнгийг худалдан авах, 2'947'220 /хоёр сая есөн зуун дөчин долоон мянга хоёр зуун хорь/ төгрөгийн анхны өртөгтэй, 43'133 /дөчин гурван мянга нэг зуун гучин гурав/ үлдэгдэл өртөгтэй эд хөрөнгийг акталж устгахыг зөвшөөрсүгэй.

2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авах, хөрөнгө устгах ажлыг ОНӨАлбаны хяналтан дор зохион байгуулж, хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн дарга Л.Бямбаад даалгасугай.


3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 05 сарын  
23 өдрийн 167-р тогтоолын хавсралт



Худалдаж авах хөрөнгө

№	Нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Ор	7	220 000	1 540 000
2	Сандал	10	15 000	150 000
	Нийт			1 690 000

Актлах хөрөнгө

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Парафин халаагч	1	605 000	605 000	605 000	0
2	Компьютер/2	1	100 000	100 000	100 000	0
3	Компьютер/3	1	530 000	530 000	530 000	0
4	Парафин халаагч/2	1	608 000	608 000	608 000	0
5	Принтер	1	215 000	215 000	215 000	0
6	Ус буцалгагч	2	20 000	40 000	20 000	0
7	Ус буцалгагч	1	180 000	180 000	164 000	16 000
8	Кушетка	1	103 500	103 500	103 500	0
9	Телевизор	1	80 000	80 000	80 000	0
10	Угаалгын машин		168 720	168 720	168 720	0
11	Ус буцалгагч	1	34 500	34 500	20 700	13 800
12	Тоос сорогч	1	80 000	80 000	66 667	13 333
13	Бичгийн ширээ	1	100 000	100 000	100 000	0
14	Утас	1	2 500	2 500	2 500	0
	Нийт дүн			2 947 220		43 133